

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр, Даваа гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-20

---

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай /	4-5
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Газар тариалангийн салбарын талаар авах арга хэмжээний тухай/	5-12
3.Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл /Санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ/	13-20

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны  
04 дүгээр сарын 15-ны өдөр /Даваа гараг/-ийн хуралдааны  
товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 26 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Б.Саранчимэг, Х.Болорчулуун, Н.Ганибал, Ц.Идэрбат, Г.Мөнхцэцэг, Т.Энхтүвшин;

Чөлөөтэй: Ц.Анандбазар, О.Цогтгэрэл.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл** /Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ж.Батжаргал:** “Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Г.Тэмүүлэн, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл** /Газар тариалангийн салбарын талаар авах арга хэмжээний тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Ж.Батжаргал, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Ц.Туваан нар үг хэлэв.

**Ж.Батжаргал:** “Газар тариалангийн салбарын талаар авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 16 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл /Санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн дарга З.Өнөржаргал, мөн Комиссын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн ахлах референт Ч.Ариунаа, Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн референт Д.Намжилсүрэн, Дотоод хамтын ажиллагаа хариуцсан референт Г.Сурахбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн талаар Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн дарга З.Өнөржаргал, мөн Комиссын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн ахлах референт Ч.Ариунаа нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн талаар сонслоо.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэхээр тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 04 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 16 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ  
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр,  
Даваа гараг  
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим,  
15 цаг 26 минут

### БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Батжаргал:** Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

2024 оны 04 сарын 15-ны өдрийн Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанд Батжаргал гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн, Бейсен гишүүн, Ганболд гишүүн, Дамдинням гишүүн, Наранбаатар гишүүн, Өнөрболор гишүүн, Тэмүүлэн гишүүн, Туваан гишүүн, Цэрэнпунцаг гишүүн хүрэлцэн ирснээр хуралдаан эхлэх бололцоотой ирц бүрдсэн байна.

Тийм учраас өнөөдрийн хуралдааныг эхлүүлж байна.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар Байнгын хорооны тогтоолын төсөл, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай,

Байнгын хорооны тогтоолын төсөл, Газар тариалангийн салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай,

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын 23 дахь илтгэл, Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдлын талаарх

дүгнэлт сонсоод, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэх.

Ийм 3 асуудал байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуулттай гишүүн бий юу. Саналтай гишүүн байна уу? Алга байна.

Байнгын хорооны хэлэлцэх асуудлыг баталлаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Тогтоолын төсөл.

**Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах Байнгын хорооны тогтоол байна.**

Байнгын хорооны болоод Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар уг хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж, Байнгын хороонд шилжүүлсэнтэй холбогдуулаад ажлын хэсэг байгуулъя.

Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

1. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч нь Ж.Батжаргал, гишүүдэд Г.Дамдинням,

Г.Тэмүүлэн,  
Ц.Цэрэнпунцаг.

О.Цогтгэрэл,

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжилтнүүдийг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсэг Батжаргалд зөвшөөрсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төслөөс асуух асуулттай гишүүд бий юу. Санал байна уу?

Асуулт байхгүй. Санал байхгүй.  
Ирц.

Гишүүд асуулт асууж, санал хэлж дууссан.

Одоо “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 хувийн саналаар дэмжигдэж, тогтоол батлагдлаа.

15.34 цаг

Дараагийн асуудалд оръё.

**Байнгын хорооны тогтоолын төсөл. Газар тариалангийн салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай.**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Дархан-Уул аймгийн Ургамал хамгаалал, газар тариалангийн хүрээлэнд “Газар тариалангийн салбарын өнөөгийн байдал, тогтвортой байдлын шийдэл, гарц” сэдэвт онол үйлдвэрлэлийн бага хурлыг зохион байгуулсан.

Уг онол үйлдвэрлэлийн бага хуралд оролцогчдоос зөвлөмж гаргасан. Энэхүү зөвлөмжийг үндэслэж Байнгын хорооноос тогтоол гаргаж, Засгийн газарт чиглэл өгье гэсэн ийм зорилготойгоор тогтоолын төсөл боловсрогдсон.

Тогтоолын төсөл танилцуулгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны газрын дарга Болорчулуун дарга нэг товч танилцуулга хийгээдхээч.

Манай байнгын хороо өөрөө санаачилж байгаа юм. Ажлын хэсгийн 2 номер, микрофон.

**Ц.Болорчулуун:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Тэгэхээр “Монгол Улсын газар тариалангийн салбарын өнөөгийн байдал, тогтвортой хөгжлийн гарц, шийдэл” сэдэвт онол үйлдвэрлэлийн бага хурлыг 03 дугаар сарын 27-ны өдөр Дархан-Уул аймагт зохион байгуулсан. Энд бол Байнгын хорооны гишүүд мөн тойргийн гишүүд, бүсчилсэн төвийн бүсийн гишүүдийн оролцоотойгоор дээрээс нь 150 гаруй тариаланчид, гурил үйлдвэрлэгчдийн төлөөллийг оролцуулсан ийм онол үйлдвэрлэлийн бага хурлыг зохион байгуулсан.

Энэ зохион байгуулж байгаа гол зорилго нь гэх юм бол яг газар тариалангийн салбар дээр бас жил болгон янз бүрийн асуудлууд тулгамдаад байгаа. Энэ нь мэдээж цаг уурын, цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулаад бусад гаднын хүчин зүйлээс хамаарч таримлын энэ чанарт янз бүрийн нөлөөлөл гарч байгаа.

Дээрээс нь энэ гурил үйлдвэрлэгч, тариаланчдын хооронд бас энэ намрын ургац хүлээж авахад тулгамддаг асуудлаас болоод янз бүрийн зөрчилдөөн байдаг гээд энэ олон асуудлууд ямар хэмжээнд байна, тэгээд үүнийг яаж цаашидаа ямар арга замаар явах вэ гэдэг тал дээр бас тал талын оролцогчдын

санал бодлыг солилцож ийм онол, үйлдвэрийн бага хурлыг зохион байгуулсан. Онол үйлдвэрлэлийн бага хуралд нийтдээ бид үндсэндээ нэг 4 чиглэлээр 30 гаруй ийм асуудлуудыг зөвлөмжид оролцогчид бол гаргасан байгаа.

I дүгээрт нь, энэ бодлогын түвшинд нэлээн асуудлуудыг ярилцсан.

Дараа нь салбарт үүсэж байгаа энэ санхүүжилт, дэмжлэгийн түвшин цаашидаа ямар хэлбэр байх вэ гэдэг талыг бас ярилцсан байгаа. Түүнчлэн энэ газар тариалангийн салбарт авч хэрэгжүүлж байгаа технологийн талаар нэлээд оролцогчид буюу эрдэм шинжилгээний байгууллагууд, эрдэмтэн, судлаачид бол нэлээд ярилцсан.

Мөн энэ эрдэм шинжилгээний байгууллагуудын өнөөгийн явуулж байгаа үйл ажиллагаа, цаашидаа ямар үйл ажиллагаа явуулах чиглэл санал бодлоо солилцож, энэ салбарын хүний нөөц, боловсон хүчний асуудлаар гэсэн ийм үндсэн нэг 5 сэдвийн дор ярилцаад, нийтдээ нэг зөвлөмжийн төсөлд 30 гаруй асуудлуудыг оруулсан байгаа. Энэ 30 асуудлыг бид багцлаад бас давхардлыг нь арилгаад, Байнгын хороотой хамтраад ингээд үндсэндээ 8 заалт бүхий Байнгын хорооны тогтоолыг ингээд оруулж байгаа. Тэгээд энэ тогтоолын төсөл бол та бүгдэд хүрсэн байгаа. Энд бол гол нь энэ хөрсний үржил шим, өнөөгийн нөхцөл байдалтай холбоотой эхний заалт орж байгаа.

Нөгөө талдаа энэ бид үрээ 100 хувь импортоор аваад байгаа. Тэгэхээр энэ үрийн аж ахуйн тогтолцоо, хуучин байсан сорт сорилын төвүүд, анхдагч үрийн аж ахуйг хэрхэн байгуулах вэ гэдэг асуудлыг бол нэлээд бас авч хөндөж үзсэн байгаа. Тэгээд одоо үүсэж байгаа нөхцөл байдалтай ер нь холбоотойгоор цаашидаа бид энэ буудайнаас өөр шинэ төрлийн таримлын хэрхэн тариалах вэ, яаж нутагшуулах вэ, яаж үйлдвэрлэлд

нэвтрүүлэх вэ гэдэг асуудлууд орсон. Түүнчлэн техник, тоног, төхөөрөмжийн механикжуулалтын түвшинийг хэрхэн нэмэгдүүлэх вэ гэдэг асуудал.

Мөн тариалангийн үйлдвэрлэлд учирч байгаа энэ эрсдэлийг хэрхэн тооцох вэ гэдэг асуудлуудыг бас нэг асуудал бас авч болгож үзсэн. Ингээд гэх мэтчилэн 8 заалттайгаар энэ өнөөдрийн тогтоолын төслийг та бүгдэд танилцуулж байгаа, товчхондоо.

**Ж.Батжаргал:** Баярлалаа.

Мэдээлэл, тогтоолын төслөөс асуух асуулттай гишүүд байна уу? Туваан гишүүнээр тасаллаа. Туваан гишүүн асуултаа асууя.

**Ц.Туваан:** Мэдээж хаврын тариалалт I сар хүрэхгүй хугацааны дараа эхлэх гэж байгаа энэ цаг үед бас энэ Байнгын хороогоор тогтоолын төсөл оруулж ирж байна. Тэгээд энэ дээр нэг 2, 3 зүйл тодруулж асууя.

Энэ сүүлийн үед үүсээд байгаа, ялангуяа энэ хууль, эрх зүйн орчинд Засгийн газраас оруулж ирж байгаа энэ гурилын гаалийн албан татвараас чөлөөлөх асуудал дээр хуулийн төсөл орж ирчихсэн байгаа. Энэ дээр Бат-Эрдэнэ гишүүнээр ахалсан ажлын хэсэг ингээд ажиллаж байгаа. Тэгэхээр энэ хуулийн төслийн хүрээнд алганы нөгөө тал нь гэдэг шиг тариалангийн салбарын асуудал энэ дээр хөндөгдөж байгаа. Тэгэхээр энэ манай өнөөдрийн энэ гарах Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны тогтоол бол бас энэ дээр нэлээн голыг нь олсон, тариаланчдад тэр эргэлзээг нь тайлсан тийм ээлтэй шийдвэрүүдийг бас энэ дотор оруулах нь зүйтэй гэж ингэж бодож байгаа юм.

Тэгэхээр энэ дээр оруулсан юун дотор энэ технологийн болон стратегийн нөөц гэдгээ нэг яг тодорхой хэлээдхээч. Ямар хэмжээ ярьж байгаа

юм бэ? Бид бүхэн бас энэ дээр нэг улаан буудай, улаан буудайн гурил өөрөө стратегийн хүнсэнд орж байгаа.

Тэгэхээр энэ дээр бид бүхэн энэ нөөц бүрдүүлэлтийн асуудлыг, ялангуяа энэ Хөдөө аж ахуйн корпорац дээр нөөц бүрдүүлэлтийн асуудлууд яриад, хэрэгжүүлээд явж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ явц, хэрэгжилт нь яг ямар байгаа юм бэ? Тэгээд энэ жилийн хувьд бол ямар хэмжээний нөөц бүрдүүлэх вэ гэж ингэж харж байгаа.

2 дугаарт нь, энэ тариалангийн тариалалт дээр нэг чухал асуудал энэ хаврын тариалалтаас өмнө энэ улаан буудайн худалдан авах үнэ зарлах гэж ярьдаг, энэ асуудал нь яг ямар шатдаа явж байгаа вэ? Үүнийг ер нь яаж тооцох юм? Одоо бас энэ чинь өөрөө эрх зүйн хувьд бол тийм бас амар асуудал биш тийм ээ, үнийг юу гэж зарлах юм? Бид нар бол өмнө нь энэ Тариалан эрхлэгчдийг дэмжих сан нэ тэрд нэг дэмжлэгүүдийг шатахууны, үрийн, бордооны гээд дэмжлэгүүд өгөөд тэр үнэдээ өрөндөө суутгаж авах улаан буудайнхаа үнийг зарлаад явдаг байсан.

Тэгэхээр одоо бол бид бүхэн энэ улаан буудайн үнийг яг энэ эргэлзээтэй нөхцөл байдал үүсчихсэн энэ цаг үед улаан буудай тариалах гэж байгаа хүмүүс маш их асууж байна л даа. Ялангуяа энэ тариалантын голыг бүрдүүлдэг энэ Төв, Дархан, Сэлэнгэ, Булган гээд энэ Хөвсгөл гээд аймгуудаас тариаланчид ярьж байна. Энэ улаан буудайн үнэ зарлах асуудлыг яг хэзээ зарлах юм бэ? Саяын Засгийн газрын хуралдаанаар бол энэ асуудал орсонгүй ээ гээд. Тэгэхээр энэ дээр бас Хөдөө аж ахуйн яам ирчихсэн байгаа учраас бас энд энэ дээр нэг тов тодорхой хариулт авъя.

3 дугаар асуудал нь бол мэдээж үрийн улаан буудайн асуудал, үрийн асуудал. Бид нар Монгол орон энэ ОХУ энэ тэртэй харьцуулахад манай тариаланчид бол маш хүнд үйлдвэрлэл

явуулж байгаа. 2 жилийн процесстой урини, тариалалт гэсэн ийм технологийн гоймон мөрдөж явж байгаа.

Дээрээс нь манай хөрсний үржил шим хөрсөө бордох энэ асуудал бол тэр зузаан хөрстэй газруудаас бол хамаагүй муу. Өөрөөр хэлбэл тийм нимгэн хөрстэй газар явагдаж байгаа. Тэгэхээр энэ дээр энэ нутагшсан үр сортын асуудлыг бид нар энэ дээр ярих юм шиг байна. Энэ Байнгын хорооны тогтоолд оруулж ирсэн байна. Энэ дээр яг тов тодорхой яг санхүү, мөнгө төгрөгийг нь шийдчихсэн ямар асуудал оруулж ирж байгаа юм. Үрийн асуудал, үрийн улаан буудайн асуудал дээр. Хариулт.

**Ж.Батжаргал:** Хариулъя. Ажлын хэсгийн 2.

**Ц.Болорчулуун:** Туваан гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр 1 дүгээрт нь, энэ технологийн болон үрийн нөөц бүрдүүлэх гэдэг асуудал байгаа. Тэгээд энэ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хангамж, аюулгүй байдал, үндэсний хөдөлгөөн, түүнийг хэрэгжүүлэх Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолд энэ нөөц бүрдүүлэх гээд жил бүр 100 хүртэл мянган тонны нөөц бүрдүүлнэ гээд тусгачихсан. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд 30, 30 тэрбум төгрөгийн төсвийг тавьж өгсөн, санхүүжилтийг. Хамгийн сүүлийн 24 оныхоо санхүүжилтээр бид 20 мянган тонн хүнсний улаан буудай, 10 мянган тонн үрийн нөөц бүрдүүлж байгаа, 5700 тонн үрийн нөөцийг бүрдүүлж байгаа.

Ингээд энэ 34 мянгынхаа зарцуулалтыг гаргаад ямар ч байсан 3 жилийн хугацаанд энэ 100 тэрбум төгрөгийн санхүүжилтээр тодорхой хэмжээний нөөц бүрдүүлэх энэ ажлаа бол зохион байгуулаад энэ нь бол Хөдөө аж ахуйн корпорац ТӨК дээр ингээд явж байгаа. Одоо сангийн компанийн мэдэлд



30 орчим мянган тонн хүнсний улаан буудай нөөцтэй байна. Энэ нь мэдээж стандартынхаа дагуу худалдаж авсан. Тэгэхдээ дийлэнх нь буюу 70 орчим хувь нь бол 3, 4 дүгээр ангиллын будаа байгаа. Тэгэхдээ бид ямар ч байсан үүнийг гурилын үйлдвэртээ ингээд борлуулах ажлаа эхнээсээ ингээд хийгээд зохион байгуулаад явж байгаа.

Үрийн нөөц дээр импортоор 5700 тонн үр худалдаж авч байгаа. Өнгөрсөн жил бид намрын ургацаас бас 2400 тонн үрийг тариаланчдаас худалдаж авсан. Ингээд өнгөрсөн жилийнхээ үлдэгдэлтэй шинээр авч байгаа үртэйгээ 13 орчим мянган тонн үрийн нөөц бол компани дээр байна. Тэгээд үүнийгээ хүсэлт нь ирчихсэн. Аж ахуйн нэгжүүддээ олгох ажлыг зохион байгуулж байна.

Өнгөрсөн 3 дахь өдрийн Засгийн газрын хуралдаанаар улаан буудайн үрийг төсвийн хөрөнгөөр худалдаж авсан улаан буудайн үнийг 30 хүртэл хувь хөнгөлөх ийм тогтоолын төсөл ороод батлагдсан. Үүгээрээ үндэслээд сайдын тушаал гараад энэ үрээ хөнгөлж олгохоор ингээд ажиллаж байна.

Дараагийн асуудал нь энэ гурил буудайтай холбоотой, ер нь энэ тариаланчид гурилын үйлдвэрүүдийн хооронд бас ийм зөрчил байгаад байдаг. Саяын ажлын хэсэг ч яваад үзэхэд ер нь хүнсний улаан буудайн стандарт гэж нэг л стандарт байгаа. Дотроо 1-4 гэсэн 4 ангилалтай. Намрын гурил үйлдвэрлэлд нийлүүлэгдэж байгаа хүнсний улаан буудай бол энэ стандартын дагуу л нийлүүлэгддэг. Тэгэхдээ гарч байгаа гомдол нь гэх юм бол стандартын байгаа хэдий боловч гурилын үйлдвэрүүд өөрсдийнхөө лабораторийн шинжилгээгээр энэ бидний буудайны чанарыг доошлуулж аваад байна гэдэг асуудал байгаад байгаа.

Тэгээд үүнийг шийдэх зорилгоор энд бол тариалангийн үйлдвэрлэлээс гарч байгаа бүтээгдэхүүний борлуулалтыг

дэмжих, стандартын шаардлага хангасан түүхий эд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нийлүүлэхэд хөндлөнгийн хараат бус лабораториор баталгаажуулах тогтолцоог бий болгоё гэсэн ийм заалт оруулж байгаа юм. Тэгээд энэ бол байж болох асуудал гэж үзэж байгаа. Юу гэхээр энд бид нар хуучин Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт байсан лавлагаа лаборатори Хабул гээд лаборатори байгаа.

Дээрээс нь Стандартчилал, хэмжил зүйн газраар бас үүнийг энэ авч байгаа энэ компанийн лабораториудыг итгэмжлэх энэ асуудал байгаа. Тэгэхээр зарим гурилын үйлдвэрүүд бол энэ итгэмжлэл хийлгэхгүйгээр энэ рүү ороод намрын ургацаа авдаг ийм асуудал байгаа. Тэгээд үүнийг нэгдсэн зохион байгуулалттайгаар оруулъя гээд Бат-Эрдэнэ гишүүний ахлуулсан ажлын хэсэгт энэ стандарттай холбоотой тэр мэргэжлийн байгууллага нь орчихсон явж байгаа. Тэгээд энэ асуудал бол шийдэгдэх байх аа гэж ингэж бодож байгаа.

Энэ үнийн асуудал байгаа. Тэгэхээр үнийн асуудлыг өнгөрсөн 3 дахь өдрийн Засгийн газрын хуралдаанаар орсон тогтоолд бас энэ үнийг оруулсан. Юу гэж оруулсан гэхээр өнгөрсөн жилийн буудайн өртөгт тулгуурласан энэ намрын ургацын улаан буудайн жишиг үнийг 4 дүгээр сард тогтоож, 8 дугаар сард бодит үнээ гаргахыг Хүнс, хөдөө ... /минут дуусав/

**Ж.Батжаргал:** Гүйцээгээд хариулчих. Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгчихье.

**Ц.Болорчулуун:** Тэр сайдад даалгасан ийм тогтоол гарсан. Тэгэхээр энэ тогтоол албажиж байгаа учраас бид 4 дүгээр сардаа тал талаасаа ажлын хэсэг болно. Яг тэр заалтаараа шахуу энд ингээд яам, холбоод, тэгээд энэ мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагад оролцсон ажлын хэсэг гараад, үнээ гаргая гэж байгаа юм.

Тэгэхээр бид нар хуучин жишиг 8 сард ургацынхаа балансыг тогтоогоод, өртөгт тулгуурласан үнэ гаргаж байсан. Тэгээд энэ жилийн жишиг үнийг эрт зарладаг нь тариаланчдыг бас тариалалтаа хэвийн явуулах нөхцөлийг нь бүрдүүлье л гэж ингэж тооцож байгаа.

Дараагийн нэг асуудал нь энэ үрийн аж ахуйн тогтолцоог хэрхэн яаж хөгжүүлэх вэ гээд. Тэгэхээр бид нар өнөөдөр энэ яг өнөөдрийн байдлаар нэг 17, 8 аж ахуйн нэгжид үрийн аж ахуй эрхлэх тусгай зөвшөөрөл олгогчоод явж байгаа юм. Тэгээд тавьж байгаа шаардлага журмынхаа хүрээнд ингээд олгохгүй байх нөхцөл байхгүй учраас олгочихсон. Тэгэхдээ ер нь бол бид анхдагч үрийн аж ахуйг зөвхөн анхдагч үрийг хэн үйлдвэрлэж байна гэхээр Дарханы Эрдэм шинжилгээний хүрээлэн л ганцаараа үйлдвэрлэж байгаа.

Тэгээд энэ анхдагч үрийн аж ахуйд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтын дэмжлэг бол зайлшгүй шаардлага байгаад байгаа. Тэгээд үүнийг бид анхдагч үрийн аж ахуй байгуулах, тэгээд гарсан үйлдвэрлэсэн үрийг нь нөгөө бүсчилсэн хэлбэрээр сорт сорилын төвүүд хуучин ажиллаж байсан. Энэ сорт сорилын төвүүд бүгд устаж үгүй болсон. Тэгээд энэ сорт сорилын төвүүдээ байгуулаад, тэгээд байгуулсан гарсан үрээ үйлдвэрлэлд нэвтрүүлэх талд нь үрийн аж ахуйгаараа дамжуулаад ингэсэн ийм нэг гинжин хэлхээний тогтолцоог бий болгоод тэгээд ер нь санхүүжилттэй холбоотой асуудлаа энэ бүх асуудал дээр заалт дээр шахуу санхүүжилтийн асуудал яригдаж байгаа.

Тэгээд хамгийн сүүлд 8 дахь заалтаараа энд шаардлагатай санхүүжилтийн оновчтой тогтолцоог бий болгож, шаардагдах хөрөнгийг жил бүр улсын төсөвт тусгах, мөн төсөл, хөтөлбөр болон хувийн хэвшлийн энэ санхүүжилтийн уялдааг хангах гэдэг

байдлаар ингээд оруулаад өгчихсөн. Тэгээд ийм байдлаар шийдээд явъя.

Ер нь энэ шинэ төрлийн таримлыг турших, сорих, нутагшуулах гээд бид нар энэ рүүгээ нэлээд түлхүү орохгүй бол зөвхөн улаан буудай сэлгээ гээд гэдэг байдлаар урини гэдэг байдлаар сэлгээд яваад байхаар зохисгүй.

Дээрээс нь нэг рапс ороод ирчихсэн. Рапс нь тэгээд намар бас өндөр үнэтэй дуудагддаг хэдий боловч яг борлуулалт дээрээ үнэ уначихдаг, зарагдахгүй асуудал байгаад байдаг. Тийм учраас бусад төрлийн ашигт таримлуудыг энэ анхдагч үрийн аж ахуйгаа түшиглэж нэлээд оруулъя гэсэн байдлаар ингэж оруулж өгсөн байгаа.

**Ж.Батжаргал:** Баярлалаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж санал хэлэх гишүүд. Дамдинням гишүүн, Туваан гишүүнээр тасаллаа. Дамдинням гишүүн.

**Г.Дамдинням:** Газар тариалангийн салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төсөл, Байнгын хорооны тогтоолын төсөл орж ирж байна. Сая би өөрийнхөө сонгогдсон тойрог, Дархан-Уул аймаг, тэгээд бас хажуугийн Сэлэнгэ аймаг өөрөөр хэлбэл Монгол Улсын Засгийн газраас тариалангийн бүс нутаг гээд зарлачихсан байгаа энэ газруудаар явж бас энэ ард иргэдтэй уулзаж, ногоочид тариачидтай уулзаад явлаа. Тэгэхээр 2 төрлийн зүйл энэ тогтоолын төсөлд бас оруулж өгөх зайлшгүй шаардлагатай байна л гэж харж байна.

1 дүгээрт, энэ саяын энэ гурилын үнэ, гурилын үйлдвэрүүд, тэгээд бас энэ тариаланчидтай холбоотой асуудлууд яваад байгаа. Тэгээд энэ дээр тариаланчид маань бид нар тариалалт

эрхлэхээрээ яг юу тарихаа мэдэхгүй байна. Тариалалтынх нь цаг эхэлчээд байна. Дараа жилийн үнийг би худалдаж авах үнээ энэ жилийнхээ намар худалдаж авах үнээ засаг яаралтай зарлачихмаар байна гэж яриад байгаа юм. Аргагүй л дээ, энэ чинь тэгээд хөөрхий нөгөө тариачид чинь нэг юм зун, намрын турш зүтгэж байгаад л хавар, зун, намрын турш зүтгэж байгаад л нэг жоохон тариа хураана. Тэгээд нөгөөдхийг нь гурилын үйлдвэрүүд нь миалж миалж нэг доош нь хийж байгаад л авна. Тэгээд өөрсдөө экспортод гаргах гэхээр чадахгүй.

Тэгэхээр нөгөө хэдийнхээ хяналтад байгаа учраас наадуул чинь хамаагүй дуугарч чадахгүй. Ингээд энэ хүмүүс чинь хөөрхий минь ингээд хэцүү байдал руу орчхож байгаа байхгүй юу.

Нөгөө талдаа гурилын үнийг хямдруулах ёстой байгаа. Гурилын үнийг хямдруулах гэдэг дээр бол ард иргэдийн уулзалт үнэхээр тодорхой байна лээ. Хямдруулах ёстой бид нар. Тэгэхээр энэ тариачдаа яг энэ тариалан эрхэлж байгаа ард иргэдээ энэ чинь хөөрхий нэг 30 мянган л хүн юм байна лээ шүү дээ. Энэ хэдэн хүнийг хэдүүлээ бас нэг хэцүү байдалд орхичихмооргүй байна. Тэгэхээр энэ тогтоолын төсөл дээрээ засгийн зарлах үнийг тэдэн сарын тэдэн гэхэд шууд зарлаа гэдэг чиглэл өгчихвөл яадаг юм бэ, бүгдээрээ. 1 дүгээр санал.

2 дугаарт, энэ тогтоолын төслийн 5 дугаар заалт дээр нэг асуудал байна. Тариалангийн салбарт учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даван туулах зорилгоор даатгалын оновчтой тогтолцоог сонгон нэвтрүүлэх, Тариалангийн даатгалын тухай хууль, Гамигийн тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулж, эрх зүйн орчныг сайжруулах гэсэн ийм заалт оржээ. Сайн. Гэхдээ энд нэг асуудал байна.

Төв аймгийн Жаргалант, Дархан-Уул аймгийн Орхон, Сэлэнгийн Орхон. Тэгээд л Шаамар. Тэгээд л Мандал гээд л энэ ногоо тарьж амьжиргаагаа залгуулдаг ард иргэдийн асуудал энд байхгүй болчихоод байгаа юм. Уржнан жил маш том үер болсон, энэ газруудаар. Батжаргал гишүүн, манай Төв аймгийнхан, Туваан гишүүн бүгдээрээ л мэдэж байгаа. Ноднин бас болсон. Жил өнжсөөд л болчихоод байгаа. Тэгээд энд нөгөө муу хэдэн ногоочдоо даатгалд хамруулах гэхээр ямар ч даатгалын систем тэнд ажилладаггүй, хэн ч даатгадаггүй.

Тэгээд аргаа бараад Дарханыхаа нөгөө муу ногоочдоос гарын үсгийг нь цуглуулаад тэр чинь бараг 800 гаруй хүний гарын үсэг ирсэн шүү дээ. Тэгээд би Хөдөө аж ахуйн яам руу өгсөн, тийм ээ. Тэгээд бас энэ Гамигийн тухай хуулийн дагуу Шадар сайдад хандаад гамшиг гэдгийг нь тогтоогоод мөнгө авах гэсэн чинь биш байна гэж хэлээд ингээд мөнгийг нь өгөөгүй, хөөрхий. Нөхөн төлбөр байхгүй.

Даатгуулж болдоггүй, зээл авч болдоггүй. Тэгээд гамшигаар нь гамшиг мөн байна гээд мөнгийг нь аваад нөхөн төлбөрийг нь аваад өгчихье гэхээр гамшиг биш байдаг. Тэгээд энэ муу хэдэн ногоочид чинь л хүнсний хувьсгал гээд бид нар баахан давхичихсан байдаг. Дотоодоосоо төмс, хүнсний ногоогоор ард иргэдээ хангана гэхихсэн байдаг. Тэгээд би ямар ч санхүүгийн эх үүсвэр байхгүй, бүр зээл ч байхгүй.

Тэгээд дээрээс нь ямар ч юу байхгүй хамгаалалт байхгүй, ёстой л нэг бор зүрхээрээ л нэг хэдэн амьтан үлдэж байгаа юм л даа. Тэгэхээр энэ 5 дугаар заалт дээр энэ тариаланчдаас гадна энэ ногоочдыг бүр тодорхой тусгаж оруулж өгмөөр байна. Бүр яг тодорхой. Өөрөөр хэлбэл энд ярьж байна шүү дээ. Тариалангийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан сэргийлэх, даван туулах зорилгоор даатгалын оновчтой

тогтолцоог сонгон нэвтрүүлэх гэдэг дээр тариаланчид, тариалан ногооны салбарын гэх юм уу, тийм ээ. Энэ найруулгыг нь хийчхэж болно биз. Ингээд нэг оруулчихмаар байх юм. Ийм нэг 2 санал байна.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Туваан гишүүн.

**Ц.Туваан:** Эхнийх нь тэр юу, энэ технологийн болон стратегийн нөөц бүрдүүлэх гээд сая Болорчулуун даргын үгэнд ч гэсэн гарч байна. Энэ өмнө нь бас нэг энэ нөөц гээд л ингээд явж байгаа. Тэгээд энэ дээр нэг 3 жилийн хугацаанд 100 орчим мянган тонн, тийм ээ, 100 орчим мянган тонн ийм нөөц бүрдүүлэх гээд.

Тэгэхээр энэ одоо байгаа нөөц чинь бас яг өнгөрсөн жилийнх юм уу? Урьдын юмаа, урьдын будаа юмнууд яасан юм гээд энэ асуудлаа хэдүүлээ бас сайн, одоо яам бодлогоо барьж явж байгаа юм чинь барьж яваарай. Тэгээд энэ нөөц дээр нэгэнтээ үндсэн зорилго чинь бол улс байна, нэг ямар нэгэн хэмжээгээр ямар ч улс ер нь стратегийн хүнсээ нөөцөлдөг, эрсдэлээ хаадаг. Тэгэхээр энэ тал дээр бас нэлээн анхаарч ажиллаасай гэж ингэж бодож байна.

Дараагийн асуудал нь энэ улаан буудайн үнийн үнэ тогтоох дээр бас Дамдинням гишүүнтэй санал нэг байна. Энэ нэг тодорхой тэдний дотор гээд нэг үнэ яаралтай ажиллачихмаар байна. Энэ судалгаан дээр яана. Өөр янз бүрийн юмнаас шалтгаалахгүй учраас энэ асуудлыг бас нэлээн яримаар байгаа. Тэгээд тэр гурилын гаалийн албан татвараас чөлөөлөх хууль дээр ч гэсэн яг судлаад үзэхээр энэ тариаланчид нэлээн өртөх магадлалтай.

Дээрээс нь тарилт буурах магадлалтай. Дээрээс нь Ерөнхийлөгчийн санаачилсан 36 дугаар тогтоолтой холбоотой нэлээн их хэмжээний зээл, санхүүжилтийг энэ газар тариалангийн

салбарынхан авчхаад, нэлээн их хэмжээтэй тарина гээд ингээд бэлдчихдэг. Тэгэнгүүт ингээд улаан буудай импортын гурил, хэмжээ хязгааргүйгээр орж ирэх ийм нөхцөл үүссэнтэй холбоотойгоор тариалалт буурах, улаан буудайн борлуулалт эрсдэлд орох асуудал үүсчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бол яг энэ талаа хааж байж, асуудлаа энэ дээр тодорхой тавьж өгөх хэрэгтэй гэсэн ийм зүйл байгаа юм.

3 дугаарх нь бол энэ хүнсний ногооны урамшуулалтай болоод бид нар энэ 2 жил өнгөрсөн. Жилээс жилд жсоохон энэ урамшууллаа авах энэ байдал хүмүүс нь дасан зохицоод ингээд яваад байгаа. Тэгэхээр энэ хүнсний ногооны урамшуулал авах дээр тэр аль болох нөгөө ногоочдоо намар хураан авах үе дээрээ ногооны үнэ нийлүүлэлт ихэссэнтэй холбогдуулаад ногооны үнэ унадаг.

Дээрээс нь тэр тэнд ажиллах хүчин, техникийн шийдэл муутай байгаа учраас ажиллах хүмүүсийн цалин, цавууны асуудал их үүсдэг учраас энэ урамшууллаа аваад бас тэр юундаа өгөх ийм нөхцөл боломжийг бол төрөөс нээж өгсөн байгаа. Тэгээд энэ дээр нэг ийм асуудал нь тэр хаана нь оруулдаг юм. Энэ хүнсний ногоотой холбоотой асуудал оруулахдаа тэр борлуулалтын талбайн асуудлыг нэлээн зохицуулах байдлаар нэг албаны маягаар яаж оруулж өгдөг юм.

Тухайлах юм бол, энэ вокзал орчмын, Барс орчмын, тэр 1000 машины зогсоол ч юм уу, эс үгүй бол энэ энд тэнд нөгөө нэг намрын худалдаа, өргөтгөсөн худалдаа маягийн зах маягийн худалдаа хийх газруудтай холбоотой санхүүгийн асуудал энэ тэрийг нь хямдруулах байдлаар өгөхгүй бол жишигээр юм бол жижигхэн газар энэ нэг ширээний хэмжээтэй жижигхэн газар л гэхэд сая 500, 2 сая гээд маш өндөр үнэтэй болоод явчихдаг. Тэгэхээр энэ удахгүй ингээд л юу юугүй сонгууль, наадам гээд л

өнгөрөхөд л ногоо борлуулах ялангуяа бүр эрт ургацын ногоонууд бол маш эрт гараад ирнэ. Тийм ээ. Тэгэхээр үүний борлуулалтын талбайтай асуудлыг энэ шийдвэртээ оруулаад өгчихвөл ямар вэ гэсэн ийм санал байна.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Тэгэхээр үнэхээрийн манай газар тариалангийн үйлдвэрлэлийн өмнө бас тулгамдсан асуудлууд байгаад байгаа юм. Сая бид нар тэр мэргэжлийн байгууллагуудтайгаа хамтраад, бодит байдал дээрээ их бодитой дүн шинжилгээ хийгээд, одоо бид хэд ер нь ямар арга хэмжээ авч байж энэ газар тариалангийн салбарын тогтвортой хөгжлийн асуудал хангагдах юм бэ гэдэг юмыг ярьцаасан.

Хөрснийхөө үржил шимийг хамгаалах, сайжруулах тухай асуудал бидэнд бол яах аргагүй тулчихсан.

2 дахь нь энэ үрийн асуудал байгаад байгаа юм. Хэн Болорчулуун дарга анхаараарай. Юу, 2 дахь заалтыг чинь сорт сорилтын төвүүдийн чинь ар дээр өнөө залгаж орж ирэх үрийн аж ахуйнуудын чинь юу орхигдсон байна? Уул нь энэ чинь ярьж, ярьж хэдүүлээ яг энэ дээрээ хэлхээгээ ингэж хийе гэсэн.

Дээр нь энд урамшууллын чинь асуудал орхигдчихоод байна. Ард байгаа урамшууллаар бол энд яригдахгүй. Энэ чинь зөвхөн таваарын улаан буудай дээрээ урамшуулал өгчхөөд, үр дээрээ өгөхгүй яваад байгаа байхгүй юу. Тэгээд үүнийгээ бол яг энэ хэлэх ёстой газар нь тов тодорхой хэлж өгөх ёстой.

Дараагийн нэг зүйл бол дотоодынхоо хэрэгцээг хангана. Технологийн болоод стратегийн нөөцөө хадгалаад, давсан хэсгээ экспортолдог байх тухай асуудлыг энд нээж өгч байгаа. Энэ тогтоолоор. Үүнийгээ их тодорхой болгож оруулах ёстой.

Түрүүн манайхан яриад байна лээ. Стратегийн нөөцдөө бол бид 100 орчим мянган тонн таваарын улаан буудай байх юм. Технологийн нөөцдөө бол нэг 18 мянга орчим тонн үрийн будаа байх юм л гэж л ингэж л харж байгаа шүү дээ.

Тийм учраас үндсэндээ 120 орчим мянган тонн үрийн болоод таваарын улаан буудай нөөцлөгдөж явна. Энэ нь байнгын байна. Мэдээж сэлгэдэг, нөхөн бүрдүүлдэг энэ зарчмаараа явах ёстой. Ингэж байж ган гачиг янз бүрийн юмнуудаа бид бас нэг стратегийн хүнс болсон гурил, гурилан бүтээгдэхүүн дээрээ асуудал үүсгэчихгүй байх, бас энэ газар тариалангийнхаа салбарын үйлдвэрлэлийг үрийнх нь хувьд бас доголдуулчихгүй байх талаас нь асуудлаа анхаараад ингээд явж байгаа гэдгийг зориуд ойлгох ёстой.

Ингээд саяын манай гишүүдийн хэлсэн саналуудыг холбогдох холбогдох заалтууд дээр нь шигтгэж аваад, тэгээд тогтоолын төслөө батлах нь зүйтэй юм байна гэж ингэж үзэж байна.

Ингээд санал хэлж дууссан.

“Газар тариалангийн салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

70 хувийн саналаар тогтоолын төсөл дэмжигдэж батлагдлаа.

16.01 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

**Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын 23 дахь илтгэлийн танилцуулга.**

Ажлын хэсгийг оруулъя. Хэн танилцуулах гэж байгаа юм. Тэгээд хэн танилцуулах юм.

Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын 23 дахь илтгэлийн танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн дарга Өнөржаргал танилцуулна. Танилцуулгыг хийе.

**3.Өнөржаргал:** Өдрийн мэндийг дэвшүүлье. Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсад Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 23 дахь илтгэлдээ, энэ удаагийн илтгэлдээ байгаль орчны асуудлаар 2 сэдвийг бичсэн байгаа.

1 дүгээрт нь, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийн асуудал.

Дахиад нэг нь иргэний нийгэм болон байгаль орчны чиглэлээр ажилладаг хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилт гэсэн ийм сэдвээр илтгэлийг боловсруулсан.

Тэгэхээр эхний сэдвийг бол. Би болохоор нөгөө 5 дугаар бүлгийнх нь сэдвийг боловсруулж бичсэн болохоор энэ бүлгийнхээ юуг танилцуулах гэсэн юм.

Илтгэлийн энэ сэдэв дээр бид нар бол иргэний нийгэм болон байгаль орчны чиглэлээр ажилладаг хүний эрх хамгаалагчийн өнөөгийн нөхцөл ямар байна? Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны хэлбэр онцлог нь ямар байна? Тэдэнд тулгамдаж буй бэрхшээл, эрсдэл ямар байдлаар даван туулж байна? Тэгээд олон улсын хэмжээнд ямар байдлаар хүний эрх хамгаалагчдын асуудлыг зохицуулж байна, үндэсний хэмжээнд ямар байна. Хууль эрх зүйн орчин, санхүү, татвар, хүний нөөц, хүний эрх хамгаалагчдын эрх зөрчигдөж буй хэлбэр, тэгээд тэндээсээ нөгөө байгаль орчны хүний эрх хамгаалагчдын гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, тэдний аюулгүй байдал, хамгаалалтын талаарх Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал жишээлбэл амь нас, бие махбодод халдах, заналхийлэх, нэр төрд нь халдах,

цахим аюулгүй байдал, үйл ажиллагаанд нь учирч буй хүндрэл, дүгнэлт, санал гэсэн ийм агуулгаар бичсэн байгаа юм.

Тэгэхээр Байгаль орчны Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль 2021 оны 4 сард батлагдаад ингээд 3 дахь жилдээ хэрэгжиж байна. Энэ хуулийн хэрэгжилтэд хяналтын чиг үүргийг бол Хүний эрхийн Үндэсний Комисс хэрэгжүүлж байгаа бөгөөд Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд хүний эрх хамгаалагчийн орон тооны бус хороо ажилладаг. Энэ хороо бол хүний эрх хамгаалагчийн аюул эрсдэлд учирсан эрх зөрчигдсөн тохиолдолд ийм дүгнэлт гаргадаг. Дүгнэлт нь болохоор шүүхийн нотлох баримт бүхий ач холбогдол бүхий хэмжээний акт болж гарах юм гэдгээрээ чухал ач холбогдолтой байгаа.

Байгаль орчны хүний эрх хамгаалагчдын тэргүүн шугамд ажилладаг хүний эрх хамгаалагчид нь бол 1 дүгээрт, байгаль хамгаалагчид, экологийн цагдаа. Тэрийг дагаад иргэний нийгмийн энэ чиглэлээр ажиллаж байгаа хүний эрх хамгаалагчид бол хамаардаг юм.

Тэгэхээр энэ бид нар бол энэ хүний эрх хамгаалагчдын өнөөгийн нөхцөл байдлыг 902 энэ чиглэлээр ажилладаг байгаль хамгаалагч, экологийн цагдаа, иргэний нийгмийн хүний эрх хамгаалагчдаас авсан социологийн анализ, тэгээд шүүхийн шийдвэр, чанарын судалгаанууд, олон улсын судалгаанууд, тэгээд өөрсдийнх нь учирч байгаа эрсдэлт бодит нөхцөл байдал дээр нь үндэслэж энэ юуг илтгэлийн энэ бүлгийг боловсруулсан байгаа.

Тэгээд судалгаанд оролцсон хүний эрх хамгаалагчдын ажиллаж буй чиглэлийг нь бид нар ингээд аваад үзэхээр ер нь бол нийтлэг байдлаар бол эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар, дараа нь бол байгаль орчны чиглэлээр, дараагийнх нь бол шударга ёсыг шаардах, тэгээд үзэл бодлоо илэрхийлэх

гээд тэгээд уулын уурхайн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн хүний эрх хамгаалагчид бол ажиллаж байна гэж хэлсэн байгаа.

Тэгэхээр энэ ер нь бол хүний эрх хамгаалагчдынх нь, мэргэжлийн үйл ажиллагаагаараа хүний эрх хамгаалж байгааг нь бол байгаль хамгаалагч, экологийн цагдаа, сайн дурын үндсэн дээр болохоор ингээд газар нутаг, өөрсдийнхөө байгаль орчны чиглэлээр тэмцэж байгаа малчид, иргэд, тэгээд иргэний нийгмийн хүний эрх хамгаалагчид гэдгээр нь бол ангилж, энэ түүвэрлэлтээ хийж явсан. 21 аймгийн түүврийг бол бүрэн хангаж оролцуулсан юм байгаа юм. Ер нь бол манай улсад нөгөө иргэний нийгмийн байгууллага тийм ээ, ТББ ашгийн төлөө хуулийн этгээдийг гэсэн ойлголтуудыг, янз бүрийн ойлголтуудыг бол энэ хуульд хэрэглэж байна. Тэгээд нөгөө холбоо сангийн хуулиар холбоо сангийн нөгөө эрх зүйн байдлыг тогтоосон бие даасан хууль байхгүй болохоор ТББ-ын тухай хуулиар зохицуулж байгаа.

Тэгээд ТББ-ын хууль болохоор яг ингээд э энэ олон улсад заасан иргэний нийгмийн байгууллага, тэгээд энэ олон нийт, ашгийн төлөө хуулийн этгээд гээд энэ бүгдийн ойлголтыг яг нэгтгэж ингээд зохицуулж чадахгүй байгаа болохоор бид нар бас энэ дээр анхаарах хэрэгтэй. Яагаад гэвэл иргэний нийгмийн байгууллагын гүйцэтгэж байгаа үүрэг нь өөрөө асар их өндөр ач холбогдолтой. Тэгээд энэ хүний эрхийг хангаж хамгаалах, тэгээд дээрээс нь төрийн үйл ажиллагааг дэмжихэд хамгийн чухал үүрэг гүйцэтгэж байдаг. Гэвч нөгөө иргэний нийгмийн байгууллагыг дэмжих төрийн бодлого байхгүй нь өөрөө бас аягүй их учир дутагдалтай байна гэж үзэж, төр, хувийн хэвшлийн бодлого бол гарчихсан байдаг. Монголд болохоор иргэний нийгмийн дэмжих бодлого одоо хүртэл ингэж батлагдаагүй байгаа юм.

Монгол Улсын хэмжээнд бол нийтдээ 31 мянган ТББ бүртгэлтэй байдаг. Тэгтэл эндээс идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь 7400. Тэгээд олон улсын нөгөө иргэний нийгмийн байгууллагуудын дэлхийн холбооны индексээр авч үзэх юм бол нөгөө 100 оноогоор ингэж үнэлдэг үнэлгээгээр авч үзэхээр манай Монгол Улс ингээд энэ дандаа буурсан үзүүлэлттэй байгаа. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдаад ноднин бол батлагдаад юу батлагдсанаар ноднингийн үзүүлэлтээр дээшилсэн боловч, 2023 оны оноогоор болохоор 67 гээд ингээд дахиад буурсан хязгаарлагдмал гэж авч үзсэн. Энэ нь юутай холбоотой вэ гэхээр нөгөө манай Эрүүгийн хуулийн зохицуулалт дээр байгаа тэр зарим зохицуулалттай холбоотойгоор энэ бол нөгөө хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг хязгаарлаж байна гэсэн тийм дүр зураг гарсан.

Тэгээд яах вэ, энд бол бид нар нэлээн олон бас нөгөө олон улсад байгаа энэ тийм ээ, ...

**Ж.Батжаргал:** Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудлаарх байдал ямар байна вэ. Хууль тогтоогчид ер нь юу анхаарах ёстой вэ гэдэг талаасаа мэдээллээ жсоохон хумьж базаж оруулж ирвэл яагаад байна.

**З.Өнөржаргал:** Тэгэхээр эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийнх нь асуудал нь бол 1 дүгээр бүлэг. Үүнийг Сүнжид дарга танилцуулах байсан. Тэгэхдээ манай ахлах референт Ариунаа ингээд танилцуулна. Би яг тэнд ажиллаж байгаа тэргүүн шугамд ажиллаж байгаа хүний эрх хамгаалагч буюу байгаль хамгаалагчид, экологийн цагдаагийнхан, иргэний нийгмийнхэнд тулгамдаж байгаа асуудалтай нь холбоотой нөхцөл байдлыг танилцуулж байна гэж. Тэгэхээр нөгөө нэг ер нь бол яг эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудал бол манайд үнэхээр тулгамдсан

асуудал болж байгаа. Тэгэхээр эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудал дээр энэ дээр тэмцэж байгаа байгаль хамгаалагч, экологийн цагдаа ч маш их олон хууль бус ингээд юмтай тэмцээд явахаар тэрийг дагаад явж байгаа иргэний нийгмийнхэнд нь асуудлыг нь ингээд тавиад шийдүүлэх гэхээр нөгөөдөх төрийн тогтолцооных нь өөрийнх нь нөгөөдөх оновчтой байдал тодорхой бус байгаагаас бас тэрийг дагаад иргэний нийгэмдээ бас энэ үйл ажиллагаа нь нөлөөлж байна гэж үзэж байгаа.

I дүгээрт, яагаад гэхээр байгаль хамгаалагчид тусгай юу, Байгаль орчны яаманд харьяалалтай байна. Дээрээс нь нийслэлд харьяалалтай байна. Дахиад дараагийнх нь болохоор юу аймаг, сумдад харьяалалтай байдаг. Тэгэхээр эд нарын нэгдсэн бодлого нь тодорхойгүй байгаагаар нь энэ өөрөө бас энэ эрүүл аюулгүй орчинд юу, амьдрах эрхийн хэрэгжилтийг хангаж хамгаалдаг энэ хүмүүст бас хүндрэл учирч байна.

Монголд 1147 байгаль хамгаалагчид байна. Экологийн цагдаа болохоор 130 байдаг. Тэгээд орон нутагт болохоор нэг нэг хүнд ингэж удирдаж явдаг байгаа. Тэгэхээр тэд нар бол ингээд хамтдаа байгаль хамгаалах үйл ажиллагаанд ингээд оролцоод явна. Тэгээд нөгөөдөх Төрийн тусгай хамгаалалттай газрынхан ингээд гүний эргүүл хийгээд ингээд явахад тэд нар нөгөөд яг ингээд Эрүүгийн хууль дээр хууль сахиулагчийн статусаар хуульчилчихсан. Тэгэхдээ яг хууль сахиулагчийн статусаар ажиллаж чаддаггүй, удирдлага нь ингээд хэд хэдэн янзаар байдаг болохоор тэрийг дагаад иргэд нь ингээд өргөдөл, гомдлоо өгөхдөө нийслэлд ингээд өгнө, асуудал нь шийдэгдэхгүй. Эсвэл тийш нь юунд сумдад өгнө, бас ингээд шийдэгддэггүй ийм хүндрэлүүд бас гардаг юм байна лээ.

Тэгээд тэнд болохоор нөгөө нэг хэрэг юу, Зөрчлийн хуулиар нөгөөдөх эрх

бүхий албан тушаалтны ажлыг хийдэг. Тэгээд нөгөө гүний эргүүлд явж байгаа хүмүүс 3 хоногийн дотор амжиж тэр нөгөө бүртгэлийг хийж чаддаггүй бас тийм хүндрэлтэй асуудлууд гарна.

Дараагийнх нь нэг асуудал нь болохоор байгаль хамгаалагчдын асуудал дээр юуг бид нар нэн яаралтай шийдвэрлэх шаардлагатай байгаа гэхээр бид нар нөгөө үнэлгээнийхээ асуудлыг нь хийхгүй бол ажлынх нь орчин нь гэр болчихдог. Гэрт нь очоод нөгөөдөх янз бүрийн торгууль, шийтгэл тавиад ингээд хууль бус юмтай тэмцэнгүүт гэрт нь очингуутаа нөгөө өс хонзонгийн шийдлээр гүйж очоод гэрт нь зодсон асуудал гарч байгаа.

Тэгэхээр бид нар хуульд энэ хүнийг гэрийг нь юу гэж ажлын байр гэж үзэх үү. Яагаад гэвэл ажлын байр дээрээ байгаагүй гэртээ байсан гэдгээрээ тэнд хэрэг үүсгэдэггүй асуудал бас гарсан байгаа. Энэ нөгөө чанарын судалгаагаар гарсан байгаа. Тэгээд энэ шүүхийн шийдвэрээс бид нар түүгээд үзэхэд түүн дээр маш олон байгаль хамгаалагчид болон гэж янз бүрийн тийм асуудалд орж дээрээс нь зодуулах, цохиулах тийм хүндрэлүүд гардаг юм байна лээ.

Дараагийнх нь болохоор байгаль хамгаалагчдын гол тулгамдаж байгаа асуудал нь юу вэ гэхээр ажлын цаг нь 40 цаг байх ёстой бол тэд нар 60-80 цаг ингэж 7 хоногт ажилладаг. Тэгээд байгаль хамгаалагчдыг дахиад бэлтгэх манай бодлого хаана бэлтгэх вэ гэдэг нь бас тодорхойгүй байгаа. Ийм асуудлууд тулгамдаж байна гэдгийг гарсан байгаа юм.

Тэгээд бид нар, нөгөө нэг энэ иргэний нийгмийнхэн иргэний нийгмийнх нь нөгөө хүний эрх хамгаалагчид байгаль орчны тэргүүн шугамд ажиллаж байгаа хүний эрх хамгаалагчдын тийм ээ, хамгаалалт аюул, эрсдэлийн асуудал нь аягүй чухал. Тэд нар аюул эрсдэлд ингээд учрах юм бол тэр хүнээс ч байж болно,



байгалиас амьтнаас ч байж болдог. Тэгэхээр тэнд бид нар ямар хамгаалалтын арга хэмжээг авах ёстой вэ, ямар зохицуулалт шаардлагатай вэ гэдэг дээр гол дүгнэлт, саналыг энэ илтгэлээрээ гаргасан юм байгаа юм. Нийтдээ 9 бодлогын саналыг бол гаргасан. Тэгээд тэндээсээ яг Улсын Их Хурлаар шийдвэрлэх шаардлагатай 3 саналыг гаргасан байгаа. Энэ нь болохоор би байгаль орчны чиглэлээр ажиллаж байгаа, байгаль хамгаалагчдын экологийн цагдаагийн асуудал ярьж байгаа болохоор энэ дээр 1 дүгээрт, байгаль орч байгаль хамгаалагчдын үнэлгээг хийж байж тэдний нөгөө ямар бие даасан хуулиар асуудлыг нь зохицуулах юм бэ гэдгийг шийдвэрлэхгүй бол 1 дүгээрт, тэр байгаль хамгаалагч чинь өөрсдөө 9 хуулийн хэрэгжилт хэд хэдэн журмын хэрэгжилтэд хяналт тавьдаг. Яг үндсэн үүргээ хийж чаддаггүй. Тэр нөгөө ЭБАТ-ын үүрэг гүйцэтгээд үндсэн ажилдаа хүрч чаддаггүй ийм нөхцөлтэй байна.

Тэгээд бас тэр нөгөө морь гол төлөв морь, тэмээгээр тийм ээ, ажлаа гүйцэтгээд ажлынх нь багаж хэрэгсэл нь бас хүрдэггүй. Одоо бол зөвхөн юуны Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагч нар бол юу олон улсын хөтөлбөр, санхүүжилтийн дэмжлэгээр энэ хувцас хангамжийнхаа асуудлыг явуулж байгаа юм байна лээ. Аймаг, орон нутаг, сумдынх бол байхгүй.

Тэгээд нийтлэг байдлаар байгаль хамгаалагч нар гол төлөв нөгөөдөх сум орон нутагт ингээд ажиллахад тэр нөгөө торгууль, шийтгэл оногдуулаад явахаар буцаагаад тэр хүмүүст ирж байгаа дарамт, заналхийллээ эсвэл үзүүлж байгаа тэр шахалтууд нь их байдаг гэдэг нь бас энэ судалгааны үр дүнгээр гарсан.

**Ж.Батжаргал:** Тэр орчны юу хэн яах юм, хийх юм? Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудлаарх. Маши товчхон. Танай дарга хаачсан юм.

Мэдээллээ хийчих.

**Ч.Ариунаа:** Мэндийг хүргэе. Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт өнөөгийн нөхцөл байдал яг энэ манай илтгэлд нийтдээ 7 бүлгээр боловсруулагдсан байгаа. Хамгийн эхний бүлэг болох 1 дүгээр бүлэгт яг энэ сэдвийг хөндсөн. Маши товч байдлаар танилцуулгыг хийе.

Ер нь бол яг энэ бүлэгт юуг хамааруулж авч үзсэн бэ гэхээр хүрээлэн буй орчны индекс дэлхий даяар индексийг гаргадаг байгаа. Гэтэл Монгол Улс ямар түвшинд байна вэ гэдгийг бас оруулж өгсөн. Монгол Улс болохоор дэлхийд 180 орноос 58-д жагсаж байна. Тэгээд Ази Номхон далайн бүс нутагтаа бас маши доогуур жагсдаг байх нь байна. Хүрээлэн буй орчны индексийг яг хэд хэдэн шалгуураар ингээж авч үзэхэд.

Тэгээд хууль, эрх зүйн орчны хувьд аваад үзэх юм бол байгаль орчны салбарт хийгдсэн 33 хууль, тогтоомжид судалгаа хийгдсэн. Судалгааны дүнд давхардал, хийдэл, зөрчил бол маши их байна. Үүнийг зохицуулах, нарийвчилж зохицуулах, давхардал хийдлийг арилгах шаардлагатай гэж дүгнэсэн ийм судалгаа байдаг. Яг хүний эрхэд нөлөөлөх хэрхэн нөлөөлж байна вэ? Энэ байгаль орчны салбарт мөрдөгдөж байгаа эрх зүйн зохицуулалтууд, хууль тогтоомжууд, эрх зүйн хэм хэмжээний актууд бусад хууль тогтоомжууд ямар нөлөөллөөр хэрхэн хэрэгжиж байна вэ гээд судалгааг хийгээд үзэхээр мөн давхардал, хийдэл, зөрчлүүд байна. Хүний эрхийг мөрдүүлэх яг энэ эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийнх нь талаас энэ утга агуулга, үзэл санааг бүрдүүлсэн хууль тогтоомж хомс байна. Мөн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах шаардлагатай байна гэсэн бас судалгааны дүн гарсан байгаа.

Яг энэ судалгааг хийхдээ 6 асуудлын хүрээнд хог хаягдал, ус, агаар,

орчны бохирдол, орчны стандартаар хийсэн байгаа.

Дараагийнх нь асуудал орчны бохирдол гэдэг дэд сэдвийг хөндсөн. Орчны бохирдолдоо агаар, хөрс, усны асуудлыг хөндсөн байгаа. Агаарын агаар орчны бохирдлыг бууруулах хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн. Гэвч хөтөлбөрийн хүрээнд агаарын бохирдол буурсан уу, хөрс, усны асуудал сайжирсан уу, бохирдол буурсан уу гэвэл ердөөсөө үгүй. Ерөөсөө л тухайн бүтцийг бол маш давтамжтайгаар өөрчлөөд яваад байсан. Одоо тэр асуудлыг хариуцсан институт бүтцийг өөрчилж байсан. Хөтөлбөрийн хүрээнд маш өргөн хүрээнд бол хөтөлбөрийг боловсруулсан учраас энэхүү хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байна гэж дүгнэсэн байгаа.

Агаарын бохирдлоос үүдээд та бүхэн мэдэж байгаа. Бид нарын уушгины хатгалгаа, амьсгалын замын халдварт өвчнүүд, тэр тусмаа архаг хууч өвчтэй хүмүүс, ахмад настан 0-5 насны хүүхдүүд гэх зэрэг энэ хүмүүс илүү өртөмтгий байдлаар байгаа.

4 үзүүлэлтээр энэ стандартыг хэмжиж байгаа ч гэсэн яг өвлийн улиралд энэхүү стандартад заасан хэмжээнээс давсан үзүүлэлттэй байгаа. Энэ нь манай Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандарт болон ДЭМБ-ын зөвлөсөн хэмжээнээс даруй хэд дахин давсан хэмжээтэй байна гэсэн дүгнэлтийг мэргэжлийн байгууллагууд, судалгаа шинжилгээний судалгаанаас харж болно. Байгууллагаас хийсэн судалгаануудаас харж болно.

Хөрсний бохирдлын асуудлыг аваад үзэх юм бол юу үүсгээд байна вэ гэхээр ерөөсөө л 200 мянган гэр хорооллын айл өрхийн 144 мянга гаруй нүхэн жорлонгийн асуудал, аюултай хог хаягдал. Энэ аюултай хог хаягдал дотор нь машины сэлбэг хэрэгсэл, аккумулятор, тос, батарей зэрэг энэ аюултай хог хаягдлууд бол эзэлж байгаа. Мөн хог

хаягдлын асуудлууд бол хөндөгдөж байгаа. Тухайн тэр хог хаягдлын асуудлуудыг хэрхэн дахин боловсруулах вэ гэдэг асуудал бид нарын тулгамдсан асуудал болж байна.

Мөн аюултай хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр бол Монгол Улсад байхгүй. Энэ асуудлууд бас тулгамдсан байгаа.

Тэгээд зуны улирал болон үер, усны асуудал үүсэх, хавар цас, мөс хайлах үед нүхэн жорлонгийн асуудал бохирууд халих гэх мэтчилэн. Энэ нь хүний эрүүл мэндэд гэдэсний халдварт өвчин үүсгэх, савханцар гэдэсний янз бүрийн савханцар үүсгэх, цусан балмад гээд янз бүрийн жишээлбэл 60 гаруй өвчин үүсгэдэг, хөрсний бохирдлоос. Хөрсний бохирдол нь хөрсөнд нэвчээд агаарт дэгдээд, агаар агаарын бохирдлоос ч аюултай ийм нөхцөл байдлыг үүсгэдэг гэсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлтүүд байдаг. Энэ дээр бид нар бас санал, зөвлөмжөө боловсруулсан байгаа.

Усны асуудал дээр гэвэл хот, суурин газар цэвэрлэх татуургын үндэсний зөвлөл болон ШУА, НҮБ-ын хүүхдийн сан зэрэг байгууллагууд хамтран 2019-2022, 2023 онд ундны усны чанарт бол судалгаа хийгдсэн байгаа. Тэр судалгаан дээр 30 гаруй хувь нь нийт тодорхой хэмжээний уст цэгүүдийн чанарыг судлахад 30 хувь нь шаардлага хангахгүй байна гэсэн дүгнэлтийг бас гаргасан байдаг. Усны газраас ирүүлсэн мэдээлэл дээр болохоор Зайсан орчмын Инэл, Номун вилаж гээд тодорхой тооны нэлээн цөөнгүй тооны хорооллууд усны чанар нь уух боломжгүй юм, заавал ч цэвэршүүлэх шаардлагатай юм гэсэн ийм дүгнэлт байдаг.

Гол горхины нөхцөл байдлыг аваад үзэх юм бол бас Туул гол орчим маш их бохирдолтой гэсэн гарсан бас судалгаанууд байдаг. Ингээд усны асуудал, хөрс, агаарын бохирдол бол

Монгол Улсын хувьд тулгамдсан асуудал болсон байна.

Дээр нь нөгөө стандартын аюулгүй байдалд амьдрах орчны стандартыг бол судалж үзсэн. Монгол Улсад нийт 6889 стандарт үйлчилж байгаагаас 2023 оны байдлаар Улаанбаатар хотод 305 сургууль, 241 цэцэрлэг, нийт тоглоомын талбай 803 буюу 82,2 хувь нь гадна орчны стандартын шаардлагыг ерөөсөө хангаагүй байна. Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа 13 сургуулиас 200 метр дотогш зайд 16 шатахуун түгээх болон авто газ түгээх цэг байрлаж байгаа нь хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах ийм эрсдэлтэй байна гэж үзэж байгаа.

Мөн Улаанбаатар хотын хэмжээнд 28 мянган өрх үерийн эрсдэлтэй бүсэд хөгжлийн бэрхшээлтэй 35166 иргэд амьдрах орчин, дэд бүтцийн хүртээмж хангалтгүй нөхцөлд амьдарч байгаа гэсэн нь болохлоор стандартын хэрэгжилт туйлын хангалтгүй байгаа юм гэсэн дүгнэлтийг хийж байгаа юм.

Мөн хариуцлагатай уур уурхайтай холбоотой бид нар Хүний эрхийн Үндэсний Комиссоос өнгөрсөн хугацаанд 5 аймгийн уул уурхайн компаниудад хяналт шалгалт, дүн шинжилгээ хийж ажилласан байгаа. Үүнтэй холбогдуулаад хүний эрхийг хамгаалсан, байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай байх зэрэг тулгуур зарч орчинд үндэслэсэн байх ёстой байтал иргэдийн тухайн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа уул уурхайн нөлөөллийн бүсийн орчинд амьдарч байгаа иргэдийн нөгөө нэг аюулгүй амьдрах эрх бол туйлын хангалтгүй байна. Мөн тэдгээр иргэдийн мэдэх эрх зөрчигдөж, хөндөгдөж байна гэсэн дүгнэлтийг хийж байгаа юм.

Тэгээд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудлаар нийт 14 саналыг гаргаж байгаа. Тэгэхээр 1 дүгээр санал нь болохоор байгаль орчны

салбарт мөрдөгдөж байгаа 30 гаруй хууль тогтоомж байна, 200 гаруй эрх зүйн хэмжээний акт, норм дүрэм, стандартууд байгаа. Эд нарыг ерөөсөө л хүний эрхийн зарчимд нийцүүлж, шалгуурт нь нийцүүлж, давхардал, хийдлийг арилгах шаардлагатай гэсэн санал байна.

Засгийн газраас 2017 оны 98 дугаар тогтоолоор баталсан Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр хэрэгжилтийг цаг хугацааны мөчлөгтэй, тухайлбал богино хугацааны, дунд хугацааны, урт хугацааны гэсэн ийм цаг хугацааны мөчлөгтэй, оновчтой хэмжигдэхүйц, биелэгдэхүйц, ач холбогдолтой шалгуураар үнэлье гэсэн ийм саналыг гаргаж байна.

Мөн агаар, ус, хөрс, орчны бохирдлыг бууруулах бодлогыг урт, богино хугацааны зорилттойгоо нийцүүлье. Яг энэ агаар орчны бохирдлын асуудлыг үндэсний хэмжээнд хариуцах бүтцийг нь яг тодорхой болгоё. Тэгэхгүй бол нөгөө бүтэц нь нэлээн дээр үеэс ингээд бүтэц нь өөрчлөгдөөд Байгаль орчны сайдын хэрэг эрхлэх асуудалд, Ерөнхий сайдын асуудлыг ингээд яваад байхаар яг ингээд тодорхой яг тогтвортой биш байгаад байгаа юм. Тэгэхээр энэ эрэмбэлж, үр дүнтэй ажиглуулахын тулд бүтцийг нь тодорхойлохдоо тогтвортой, тэгээд салбар хоорондын уялдаа холбоог хангасан үр дүнтэй байдлаар ажиглуулъя гэсэн саналыг гаргаж байгаа юм.

Мөн орчны бохирдлыг бууруулах санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлъя. Яагаад гэхээр энэ яг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нэлээн их хэмжээний мөнгө зарцуулагдахаар ийм судалгааг хийсэн байгаа. НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс. Гэтэл яг энэ санхүүжилтийнх нь 80 хувь нь хаанаас гаргах вэ гэсэн бас ийм тодорхойгүй байдал үүсгэсэн учраас санхүүгийн эх үүсвэрийг тооцоолж, хэрэгжүүлэхдээ

арга хэмжээг нь эрэмбэлье, үр ашигтай байдлаар зарцуулъя гэсэн саналыг хийж байгаа.

Орчны бохирдлыг бууруулахад төр, хувийн хэвшлийн байгууллагын түншлэлийг хөгжүүлбэ. Инновац, технологийн дэвшлийг ашиглах хувийн хэвшлийн татварыг зээлийн бодлогоор дэмжбэ гэсэн саналыг бас гаргасан байгаа.

Агаар, ус, хөрс орчны бохирдлын тандалт, хяналт шинжилгээний сорьцын мэдээллийн санг бүрдүүлээд, харилцан мэдээлэл солилцох горимыг тогтооё гэсэн байгаа. Мөн агаарын бохирдолтой холбоотой мэдээж дотоод орчны чанарт тавигдах бас суурь үзүүлэлт Монгол Улсын хэмжээнд байхгүй байна. Тэгэхээр дотоод орчныг хэрхэн яаж хэмжих вэ. Суурь үзүүлэлт байхгүй юмыг чинь юутайгаа хэмжиж, түүнийг гаргах вэ гэсэн асуудал бас тавигдаж байгаа. Тэгэхээр суурь үзүүлэлт бүхий шаардлага стандартыг шинэчлэн баталъя, хэрэгжилтэд нь хяналт тавъя. Дотоод орчны чанарын лабораторийн хэмжилтийн дүгнэлтийг олон нийтэд болгоё гээд яг дотоод орчны судалгааг хийгээд Ногоон титэм гээд компани судалгааг хийхээр, олон нийтэд бид нар мэдээлэх боломжгүй байна. Сургууль, цэцэрлэгийн орчин бол дотоод орчны шинжилгээгээр бол шаардлага хангах уу гэсэн дүгнэлт гардаг юм гэсэн бас мэдээллийг бидэнд ирүүлж байсан.

Хог хаягдлын менежментийг сайжруулах, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр, аюултай хог хаягдлыг устгах дахин боловсруулах шаардлага хангасан төвлөрсөн байгууламжийг байгуулъя гэсэн саналыг гаргаж байгаа.

Ариун цэврийн байгууламж буюу нүхэн жорлонг шинэчлэх, стандартад нийцсэн эко ариун цэврийн байгууламжаар сольё, ариутгал халдваргүйжүүлэлтийг ерөөсөө тогтмол

хийе. Хөрсний бохирдолтой газрыг нөхөн сэргээх, ногоон бүс байгуулах, ургамал мод тарих зэрэг арга технологийг хэрэглээнд нэвтрүүлбэ.

Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг шинэчилбэ. Усны бохирдлыг бууруулах, хаягдал усыг дахин ашиглах технологийг нэвтрүүлэх, газрын доорх усны нөөцийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг үе шаттайгаар хязгаарлах, усны салбарын чадавхыг бэхжүүлэхэд улсын төсөвт төвлөрсөн хураамжийг зарцуулах. Яагаад гэхээр Ус ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт нь бол туйлын хангалтгүй байгаа. Гэтэл усаа ашиглачхаад тэр усны мөнгө нь ашиглалтынх нь төлбөр нь улсын төсөвт шууд орчхож байгаа юм. Тэгэхээр усных нь мөнгийг нь усныхаа хаягдал усыг цэвэршүүлэх энэ үйл ажиллагаанд зарцуулъя гэсэн бас нэг санал байгаа юм.

Барилга, зам тээвэр, гудамж талбай, орчны стандартыг мөрдүүлэх, зөрчлийг шуурхай таслан зогсоох, харууцлага тооцож ажиллая. Яагаад гэвэл маш олон тооны стандартууд хэрэгжээд байна. Гэтэл стандарт ерөөсөө мөрдөгдөхгүй байна. Манайх яг илтгэлдээ болохоор ер нь кэйс тохиолдлуудыг маш сайн оруулж өгсөн байгаа. Стандарт хэрэгжихгүйн улмаас хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө нь бол хохирол учирсаар байна гэсэн бас энэ кэйс тохиолдлуудыг оруулсан байгаа.

Хамгийн сүүлийн санал болохоор орчны бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө, урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээллийг олон нийтэд тогтмол хүртээмжтэй хүргэх, НЭМҮТ-ийн үйл ажиллагааг сайжруулах гэсэн ийм нийт 14 саналыг багцалж гаргаж байна. Баярлалаа.

**Ж.Батжаргал:** Баярлалаа.

*Хүний эрхийн, эрх чөлөөний илтгэлд дурдагдсан, дан дамаа хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудлаарх мэдээллийг сонслоо.*

*Их Хурлын түвшинд, ер нь төрийн түвшинд энэ эрхийг хангах чиглэлээр анхаарах ёстой асуудлуудын талаарх мэдээллээ бид авлаа.*

*Тийм учраас асуудлаа танилцуулж хэлэлцүүлэх ёстой дарга нь ч эзгүй байна. Тийм учраас бид сонслоо гээд өнөөдрийн хуралдааныг өндөрлүүлж байна.*

*Хэлэлцэх асуудал дуусаж байна.*

*16.30 цаг*

*Ингээд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг өндөрлүүлье.*

*Хуралдаандаа ирж оролцсон Байнгын хорооныхоо гишүүдэд баярлалаа.*

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ**

**П.ОЮУНГЭРЭЛ**